

“ХИШИГ-УУЛ” ХУВЬЦААТ КОМПАНИ
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР

2018 оны 04 сарын 25

Улаанбаатар хот

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх хэсэг, 63 дугаар зүйлийн 63.5 дахь хэсэг, 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэг, “ХИШИГ-УУЛ” ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.3, 7.4, 7.8.3 дахь хэсгийг тус тус удирдлага болгон “Хишиг-Уул” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах дараахь асуудлуудыг **ШИЙДВЭРЛЭХ НЬ:**

НЭГДҮГЭЭР АСУУДАЛ. Компанийн 2017 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай;

1. Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.11 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх хэсэг, “ХИШИГ-УУЛ” ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.3 дахь хэсгийг тус тус удирдлага болгон компанийн 2017 оны үйл ажиллагаа тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж баталсугай.

ХОЁРДУГААР АСУУДАЛ. Компанийн 2017 оны санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай;

2. Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.11 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх хэсэг, “ХИШИГ-УУЛ” ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.3 дахь хэсгийг тус тус удирдлага болгон компанийн 2017 оны санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж баталсугай.

ГУРАВДУГААР АСУУДАЛ. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны үйл ажиллагааны тайланг танилцуулах

3. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 үйл ажиллагааны тайланг сонсож, цаашид компанийн үйл ажиллагаанд шаардлагатай дэмжлэг туслалцаа үзүүлэн ажиллахыг даалгасугай.

ДӨРӨВДҮГЭЭР АСУУДАЛ. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг улируулан сонгох

4. Төлөөлөн удирдах зөвлөлийн дараахь гишүүдийг улируулан сонгосугай.

- 1) Д.Энхтөр
- 2) Ч.Ням-Оюун
- 3) Ч.Мөнхбаяр
- 4) Я.Нэргүй

- 5) Ц.Роза
- 6) Б.Энххорол
- 7) Д.Гонгор
- 8) Н.Цэцэнхаан
- 9) Д.Сэржамц


ТАВДУГААР АСУУДАЛ. Компанийн 2018 оны үйл ажиллагааны талаар хэлэлцэх

5. Компани 2018 онд түрээсийн үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх, цаашид үйл ажиллагаагаа хэрхэн өргөжүүлэх боломжийн талаар судлан ажиллахыг ТУЗ-д даалгасугай.

ЗУРГААДУГААР АСУУДАЛ: Эдийн засгийн хямралыг давахын тулд компанийн үйл ажиллагааг тогтвортой явуулах зорилгоор 2017 онд 240.000.000 төгрөгийн хөрөнгө оруулалтыг оруулж, шаардлагатай үйл ажиллагаанд зарцуулсан тухай тайланг хэлэлцэж батласугай.

Бусад: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын шийдвэрийг хэрэгжүүлж зохих бүртгэлийг хуульд заасан хугацаанд тус тус зохих журмын дагуу бүртгүүлэхийг Өмгөөллийн “И Эл Си” ХХН-ийн хуульч С.Батчимэг, Т.Оюун-Эрдэнэ \РД:У397032985\ нарт даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ



Я.НЭРГҮЙ

Ц.РОЗА

“Нийслэлийн Өмчийн Харилцааны
Газар”-ын итгэмжлэгдсэн төлөөлөгч

A handwritten signature in black ink, appearing to be 'Ч.Мөнхбаяр', written over the stamp area.

Ч.МӨНХБАЯР